



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор: Ө.Болортуяа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	9
5.1 Төлбөрийн акт.....	9
5.1 Албан шаардлага.....	9
5.2 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.25 № 349
танай _____-ны № _____-т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БАТТУВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 12,948,997.1 мянган төгрөгийн өртөгтэй 6.6 км автозамыг хүлээн авч хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны Б/03 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 94,318,433.9 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 94,081,925.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө 5 бүлгийн хүрээд 80 арга хэмжээг хэрэгжүүлэн 87.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4626050554

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,892.2	26,255.4
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,676.6	23,187.0
3	1.1.3 АВЛАГА	105.1	311.4
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	-	52.5
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	1,552.5	1,941.8
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	56.8	220.6
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	501.3	542.2
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	55,840.4	83,703.5
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	55,840.4	83,703.5
10	1.2.2.02 Биет хөрөнгө	54,393.3	79,661.7
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	1,447.1	4,041.8
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	82,732.6	109,958.9
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,377.8	26,635.0
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,254.6	2,235.1
15	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,123.2	24,399.9
16	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,354.8	83,323.9
17	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	63,354.8	83,323.9
18	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	6,215.7	7,544.4
19	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	351.0	1,609.9
20	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	56,672.6	74,054.0
21	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	19,771.0	56,705.9
22	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	36,901.5	17,348.1
23	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115.6	115.6
24	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	82,732.6	109,958.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	129,930.5	238,018.6
2	1.1.1.03. ТАТВАРЫН ОРЛОГО	72,308.9	92,933.6
3	1.1.1.04. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,021.7	145,084.9
4	1.1.1.05. ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,599.9	-
5	1.1.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	85,421.6	209,081.6
6	1.1.2.01. УРСГАЛ ЗАРДАЛ	85,421.6	209,081.6
7	1.1.2.01.1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,624.1	20,291.4
8	1.1.2.01.1.01. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,274.4	2,652.8
9	1.1.2.01.1.02. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160.1	214.0
10	1.1.2.01.1.03. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,058.0	1,427.1
11	1.1.2.01.1.04. Хангамж, бараа материалын зардал	630.9	5,206.3
12	1.1.2.01.1.05. Нормативт зардал	-	3.2
13	1.1.2.01.1.06. Эд хогшил, урсгал засварын зардал	538.7	478.2

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	1.1.2.01.1.07. Томилолт, зочны зардал	8.6	8.9
15	1.1.2.01.1.08. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,184.4	2,077.2
16	1.1.2.01.1.09. Бараа үйлчилгээний бусад зардал	6,768.9	8,223.8
17	1.1.2.01.3. ТАТААС	-	160.0
18	1.1.2.01.4. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,797.5	188,630.1
19	1.1.2.01.4.01. Засгийн газрын урсгал шилжүүлэг	50,193.5	188,518.0
20	1.1.2.01.4.02. Бусад урсгал шилжүүлэг	239.7	112.1
21	1.1.2.01.4.04. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,364.3	-
22	1.1.2.01.4.04.01. Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	18,790.2	-
23	1.1.2.01.4.04.03. Төвлөрүүлэх шилжүүлэг	4,570.0	-
24	1.1.2.01.4.04.05. Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4.1	-
25	1.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,508.9	28,937.0
26	1.2.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,607.4	11,588.9
27	1.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-7,607.4	- 11,588.9
28	1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	36,901.5	17,348.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	112,657.8	222,168.6
2	1.1.1.1.03. ТАТВАРЫН ОРЛОГО	72,308.9	92,933.6
3	1.1.1.1.03.1. Орлогын албан татвар	55,473.4	77,169.4
4	1.1.1.1.03.3. Хөрөнгийн албан татвар	11,165.0	9,782.2
5	1.1.1.1.03.8. Бусад татвар, төлбөр, хураамж	5,670.5	5,982.0
6	1.1.1.1.04. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,749.0	129,234.9
7	1.1.1.1.04.1. Нийтлэг татварын бус орлого	12,749.0	6,647.1
8	1.1.1.1.04.3. Тусламжийн орлого	-	118,768.9
9	1.1.1.1.04.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	3,818.9
10	1.1.1.1.05. ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,599.9	-
11	1.1.1.2. НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,390.6	206,875.4
12	1.1.1.2.01. УРСГАЛ ЗАРДАЛ	86,390.6	206,875.4
13	1.1.1.2.01.1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,292.7	14,330.1
14	1.1.1.2.01.1.02. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	323.9	218.9
15	1.1.1.2.01.1.03. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,058.6	1,252.3
16	1.1.1.2.01.1.04. Хангамж, бараа материалын зардал	1,166.9	2,381.3
17	1.1.1.2.01.1.05. Нормативт зардал	-	3.2
18	1.1.1.2.01.1.06. Эд хогшил, урсгал засварын зардал	551.6	505.0
19	1.1.1.2.01.1.07. Томилолт, зочны зардал	8.6	8.9
20	1.1.1.2.01.1.08. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,603.7	2,768.8
21	1.1.1.2.01.1.09. Бараа үйлчилгээний бусад зардал	2,397.3	3,478.2
22	1.1.1.2.01.3. ТАТААС	-	160.0
23	1.1.1.2.01.4. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,097.9	192,385.3
24	1.1.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,267.2	15,293.2
25	1.1.2.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	8,352.9	16,776.9
26	1.1.2.2.01. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,352.9	16,776.9
27	1.1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	16,776.9
28	1.1.3.4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	5.9
29	1.1.3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	5.9
30	1.1. НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	17,914.3	1,489.6
31	1.2. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,762.3	24,676.6
32	1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,676.6	23,187.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,566.7	115.6	19,771.0	26,453.3
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,566.7	115.6	19,771.0	26,453.3
3	Тайлант үеийн үр дүн	-	-	36,901.5	36,901.5
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,566.7	115.6	56,672.6	63,354.8
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,566.7	115.6	56,672.6	63,354.8
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	20.8	20.8
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,566.7	115.6	56,693.3	63,375.6
8	Өмчид гарсан өөрчлөлт	1,258.9	-	12.6	1,271.5
9	Тайлант үеийн үр дүн	1,328.7	-	17,348.1	18,676.8
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,154.4	115.6	74,054.0	83,323.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1. НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	192,471.8	194,594.3
2	3.1.01.1.1. Татварын орлого	93,413.5	92,933.6
3	3.1.01.1.1.1. Орлогын албан татвар	72,820.7	77,169.4
4	3.1.01.1.1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	73,184.9	77,533.6
5	3.1.01.1.1.1.1.01. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	70,041.0	73,623.0
6	3.1.01.1.1.1.1.02. Үйл ажиллагааны орлого	150.0	309.3
7	3.1.01.1.1.1.1.03. Хөрөнгийн орлого	193.9	331.3
8	3.1.01.1.1.1.1.07. Шууд бус орлого	2,800.0	3,269.9
9	3.1.01.1.1.1.2. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 364.2	- 64.2
10	3.1.01.1.1.1.2.01. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 364.2	- 364.2
11	3.1.01.1.1.3. Хөрөнгийн албан татвар	15,092.8	9,782.2
12	3.1.01.1.1.3.1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	15,000.0	9,678.3
13	3.1.01.1.1.3.2. Бууны албан татвар	1.8	1.9
14	3.1.01.1.1.3.4. Малд ногдуулах албан татвар	91.0	102.1
15	3.1.01.1.1.8. Бусад татвар, төлбөр, хураамж	5,500.0	5,982.0
16	3.1.01.1.1.8.1. Бусад нийтлэг төлбөр, хураамж	400.0	393.0
17	3.1.01.1.1.8.1.01. Улсын тэмдэгтийн хураамж	50.0	46.2
18	3.1.01.1.1.8.1.06. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	150.0	79.3
19	3.1.01.1.1.8.1.08. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	200.0	267.4
20	3.1.01.1.1.8.2. Газрын төлбөр	5,100.0	5,536.0
21	3.1.01.1.1.8.2.01. Газрын төлбөр	5,100.0	5,536.0
22	3.1.01.1.1.8.3. Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	53.1
23	3.1.01.1.1.8.3.03. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	53.1
24	3.1.01.1.2. Татварын бус орлого	99,058.3	101,660.7
25	3.1.01.1.2.1. Нийтлэг татварын бус орлого	920.9	1,167.5
26	3.1.01.1.2.1.3. Торгуулийн орлого	900.0	1,147.7
27	3.1.01.1.2.1.5. Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	16.0	19.2
28	3.1.01.1.2.1.7. Газрын тосны орлого	4.9	-
29	3.1.01.1.2.1.9. Бусад орлого	-	0.6
30	3.1.01.1.2.3. Тусламжийн орлого	94,318.4	96,674.2
31	3.1.01.1.2.3.5. Төсвөөс санхүүжих	94,318.4	96,674.2
32	3.1.01.1.2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,818.9	3,818.9
33	3.1.01.1.2.4.2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,818.9	3,818.9

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

34	3.1.01.2. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,862.6	196,854.0
35	3.1.01.2.1. УРСГАЛ ЗАРДАЛ	94,277.4	184,716.5
36	3.1.01.2.1.1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,637.4	9,639.5
37	3.1.01.2.1.1.1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,878.0	1,576.8
38	3.1.01.2.1.1.1.01. Үндсэн цалин	748.1	687.6
39	3.1.01.2.1.1.1.02. Нэмэгдэл	748.5	635.2
40	3.1.01.2.1.1.1.03. Унаа хоолны хөнгөлөлт	279.6	207.8
41	3.1.01.2.1.1.1.04. Урамшуулал	101.9	46.1
42	3.1.01.2.1.1.2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234.8	199.1
43	3.1.01.2.1.1.2.01. Тэтгэврийн даатгал	159.6	140.2
44	3.1.01.2.1.1.2.02. Тэтгэмжийн даатгал	18.8	16.0
45	3.1.01.2.1.1.2.03. ҮОМШӨ-ний даатгал	9.4	8.1
46	3.1.01.2.1.1.2.04. Ажилгүйдлийн даатгал	9.4	7.9
47	3.1.01.2.1.1.2.05. Эрүүл мэндийн даатгал	37.6	26.9
48	3.1.01.2.1.1.3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,126.8	1,252.3
49	3.1.01.2.1.1.3.01. Гэрэл, цахилгаан	456.8	271.5
50	3.1.01.2.1.1.3.02. Түлш, халаалт	1,240.5	729.3
51	3.1.01.2.1.1.3.03. Цэвэр, бохир ус	392.5	235.9
52	3.1.01.2.1.1.3.04. Байрны түрээс	37.0	15.6
53	3.1.01.2.1.1.4. Хангамж, бараа материалын зардал	1,633.3	1,592.6
54	3.1.01.2.1.1.4.01. Бичиг хэрэг	39.5	27.9
55	3.1.01.2.1.1.4.02. Тээвэр, шатахуун	72.5	59.5
56	3.1.01.2.1.1.4.03. Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25.7	17.0
57	3.1.01.2.1.1.4.05. Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,426.3	1,432.7
58	3.1.01.2.1.1.4.06. Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69.3	55.6
59	3.1.01.2.1.1.5. Нормативт зардал	7.5	3.2
60	3.1.01.2.1.1.5.03. Нормын хувцас, зөөлөн эдлэл	7.5	3.2
61	3.1.01.2.1.1.6. Эд хогшил, урсгал засварын зардал	526.6	505.0
62	3.1.01.2.1.1.6.04. Урсгал засвар	526.6	505.0
63	3.1.01.2.1.1.7. Томилолт, зочны зардал	19.9	8.9
64	3.1.01.2.1.1.7.02. Дотоод албан томилолт	19.9	8.9
65	3.1.01.2.1.1.8. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,117.4	1,256.4
66	3.1.01.2.1.1.8.01. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,117.4	1,256.4
67	3.1.01.2.1.1.9. Бараа үйлчилгээний бусад зардал	6,093.2	3,245.2
68	3.1.01.2.1.1.9.01. Бараа үйлчилгээний бусад зардал	6,008.2	3,188.2
69	3.1.01.2.1.1.9.02. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85.0	56.9
70	3.1.01.2.1.3. ТАТААС	160.0	160.0
71	3.1.01.2.1.3.2. Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	160.0	160.0
72	3.1.01.2.1.3.2.01. Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	160.0	160.0
73	3.1.01.2.1.4. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,479.9	174,917.1
74	3.1.01.2.1.4.1. Засгийн газрын урсгал шилжүүлэг	79,327.4	174,805.4
75	3.1.01.2.1.4.1.01. Засгийн газрын дотоод шилжүүлэг	79,327.4	78,131.2
76	3.1.01.2.1.4.1.03. Төсвийн санхүүжилт	-	96,674.2
77	3.1.01.2.1.4.2. Бусад урсгал шилжүүлэг	152.5	111.7
78	3.1.01.2.1.4.2.04. Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26.2	8.7
79	3.1.01.2.1.4.2.06. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25.0	21.1
80	3.1.01.2.1.4.2.07. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7.3	-
81	3.1.01.2.1.4.2.08. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94.0	81.8
82	3.1.01.2.2. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,585.2	12,137.4
83	3.1.01.2.2.4. Бусад хөрөнгө	26,585.2	12,137.4
84	3.1.01. ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	71,609.2	- 2,259.6
85	3.1. АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 71,609.2	2,259.6
86	3. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 71,609.2	2,259.6
87	4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	22,709.2
88	5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,449.6
89	6. ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	84	84
90	6.1. БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
91	6.1.01. Төсвийн байгууллага	6	6
92	6.2. АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

93	6.2.01. Удирдах ажилтан	9	9
94	6.2.02. Гүйцэтгэх ажилтан	15	15
95	6.2.03. Үйлчлэх ажилтан	6	6
96	6.2.04. Гэрээт ажилтан	9	9
97	6.5. ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	39
98	6.5.01. Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	18
99	6.5.09. Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
100	6.5.10.Гэрээт ажилтан	9	9
101	6.5.11.Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1. НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,885.8
2	1.1.1.1.1. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,885.8
3	1.1.1.1.1.1.1.3. ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,802.1
4	1.1.1.1.1.1.1.1.4. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3.8
5	1.1.1.1.1.1.1.1.5. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79.9
6	1.1.1.2. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,630.7
7	1.1.1.2.1. УРСГАЛ ЗАРДАЛ	214.1
8	1.1.1.2.1.1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214.1
9	1.1.1.2.1.1.1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163.2
10	1.1.1.2.1.1.1.2. Нэмэгдэл	4.6
11	1.1.1.2.1.1.1.4. Урамшуулал	158.5
12	1.1.1.2.1.1.2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19.8
13	1.1.1.2.1.1.2.1. Тэтгэврийн даатгал	13.8
14	1.1.1.2.1.1.2.2. Тэтгэмжийн даатгал	1.4
15	1.1.1.2.1.1.2.3. ҮОМШӨ-ний даатгал	1.4
16	1.1.1.2.1.1.2.4. Ажилгүйдлийн даатгал	0.8
17	1.1.1.2.1.1.2.5. Эрүүл мэндийн даатгал	2.5
18	1.1.1.2.1.1.4. Хангамж, бараа материалын зардал	3.4
19	1.1.1.2.1.1.4.2. Тээвэр, шатахуун	3.4
20	1.1.1.2.1.1.9.Бараа үйлчилгээний бусад зардал	27.7
21	1.1.1.2.1.1.9.1.Бараа үйлчилгээний бусад зардал	25.0
22	1.1.1.2.1.1.9.2.Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2.7
23	1.1.1.2.2. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,416.6
24	1.1.1.2.2.1.4.Бусад хөрөнгө	4,416.6
25	1.1.1.ЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	255.1
26	1.1.АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 255.1
27	1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 255.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 102.0 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тайлант онд 102.0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг буруу зардлаар илэрхийлсэн;

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 707.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 119.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдаан зохион байгуулахад нийт 12.0 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *"Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"*, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн *"Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай"* 03 албан даалгаврын 1.6-д *"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах"* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт- 2. Тайлант онд Шинэ мянган айл" орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн 74 төрийн албан хаагчийг хамруулсан боловч 15 албан хаагчид зөврийн орон сууц авахад зориулж 190.9 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д *"аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх"*-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-3. Тайлант онд Тайлант онд төсөл, арга хэмжээний зардлаас 78.6 сая төгрөгийн судалгаа, шинжилгээний ажлын зардал гарсан боловч тус судалгааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д *"хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д *"хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-4. "Мэргэшсэн чадамжтай эмч" хөтөлбөрийн зардлаас Сум дундын эмнэлэгт 16.1 сая төгрөгийн ус цэвэршүүлэгч төхөөрөмж, "Эрчимжсэн үйлдвэрлэл" хөтөлбөрийн зардлаас Сөн дүүрэн хоршоо-д 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д *"хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д *"хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх"* -тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-5. Тайлант онд БНХАУ-ын Хөх хотод багийн засаг дарга нар туршлага судлах зардалд 20.0 сая төгрөг, Баяннуур аймагт нөхөрсөг хамтын ажиллагааны хөтөчийн зардалд 19.5 сая төгрөг, ЗДТГ-ын албан хаагчид БНСУ-ын Жонбук их сургуульд туршлага судлах зардалд 60.0 сая төгрөг, нийт

99.5 сая төгрөгийг тус бүр шууд гэрээ байгуулсан, туршлага судалснаар ямар үр дүн гарсан нь баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-6. Төсөл, хөтөлбөрийн зардлыг түүвэрлэн шалгахад "Өсөлттэй үйлдвэрлэл" хөтөлбөрийн зардлаас төсөл сонгон шалгаруулж 5 иргэнд 40.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-7. Тайлант онд "Чадварлаг малчин" хөтөлбөрийн зардлаас нэг бүр нь 4.9 сая төгрөгийн 9 ширхэг хээлтүүлгийн хуц худалдан авч 3 багийн 9 айл өрхөд өгсөн ч бүртгэлд тусгаагүй, гэрээ байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2026 оны 2 дугаар улиралд багтаан ЗДТГ-ын хөрөнгөнд 9 ширхэг хонийг бүртгэж, өрх бүртэй гэрээ байгуулж ажиллах.

Илрүүлэлт-8 Байгаль хамгаалагч Л.Энхнаранд 1.5 сая төгрөгийн сургалтын дэмжлэгийг хувийн дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-9 Тайлант онд соёлын төвийн 2025 оны ажлын тайлангийн урлагийн тоглолтын зардалд 14.7 сая төгрөгийг Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт-10. ЗДТГ-ын дарга В.Хүүхэндүүд 2024 онд сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон, 2025 онд дахин 3.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагналыг, урамшуулал, дэмжлэг олгох", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 2.3."Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж, үйл ажиллагаа нь идэвхижүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт-1. "Эх хүүхдийн эрүүл мэнд", "Эрүүл ирээдүй", "Ухамсартай монгол", "Ухамсартай эрчүүд", "Мэдлэгтэй, чадвартай, ёс зүйтэй иргэн", "Мэргэшсэн чадамжтай эмч", "Мэргэшсэн чадамжтай багш", "Мэргэшсэн, чадамжтай боловсон хүчин" гэх мэт ижил төстэй, зорилго нэг хөтөлбөрийг олон төрөл болгон баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах

Илрүүлэлт-2. Тайлант хугацаанд 236.5 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөө биелээгүйд нөлөөлсөн хүчин зүйлсийг бодитой тодорхойлж, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын уялдааг сайжруулах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 102.0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг буруу зардлаар илэрхийлсэн	1	102.0			1	102.0	1	102.0				
Дүн	1	102.0			1	102.0	1	102.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	"Эх хүүхдийн эрүүл мэнд", "Эрүүл ирээдүй", "Ухамсартай монгол", "Ухамсартай эрчүүд", "Мэдлэгтэй, чадвартай, ёс зүйтэй иргэн", "Мэргэшсэн чадамжтай эмч", "Мэргэшсэн чадамжтай багш", "Мэргэшсэн, чадамжтай боловсон хүчин" гэх мэт ижил төстэй, зорилго нэг хөтөлбөрийг олон төрөл болгон баталсан	1	0							1	0				
2	Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдаан зохион байгуулахад нийт 12.0 сая төгрөг зарцуулсан	1	12.0			1	12.0								

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

3	Тайлант хугацаанд 236.5 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	236.5					1	236.5				
4	"Шинэ мянган айл" орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн 74 төрийн албан хаагчийг хамруулсан боловч 15 албан хаагчид зөөврийн орон сууц авахад зориулж 190.9 сая төгрөгийн дэмжлэг олгосон	1	190.9			1	190.9						
5	Тайлант онд төсөл, арга хэмжээний зардлаас 78.6 сая төгрөгийн судалгаа, шинжилгээний ажлын зардал гарсан боловч тус судалгааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлээгүй	1	78.6			1	78.6						
6	"Мэргэшсэн чадамжтай эмч" хөтөлбөрийн зардлаас Сум дундын эмнэлэгт 16.1 сая төгрөгийн ус цэвэршүүлэгч төхөөрөмж, "Эрчимжсэн үйлдвэрлэл" хөтөлбөрийн зардлаас Сөн дүүрэн хоршоо-д 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан	1	26.0			1	26.0						
7	БНХАУ-ын Хөх хотод багийн засаг дарга нар туршлага судлах зардалд 20.0 сая төгрөг, Баяннуур аймагт нөхөрсөг хамтын ажиллагааны хөтөчийн зардалд 19,5 сая төгрөг, ЗДТГ-ын албан хаагчид БНСУ-ын Жонбук их сургуульд туршлага судлах зардалд 60.0 сая төгрөг, нийт 99.5 сая төгрөгийг тус бүр шууд гэрээ байгуулсан, туршлага судалснаар ямар үр дүн гарсан нь баримтаар нотлогдохгүй	1	99.5			1	99.5						
8	"Өсөлттэй үйлдвэрлэл" хөтөлбөрийн зардлаас төсөл сонгон шалгаруулж 5 иргэнд 40.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон	1	40.0			1	40.0						
9	Тайлант онд "Чадварлаг малчин" хөтөлбөрийн зардлаас нэг бүр нь 4.9 сая төгрөгийн 9 ширхэг хээлтүүлгийн хуц худалдан авч 3 багийн 9 айл өрхөд өгсөн ч бүртгэлд тусгаагүй, гэрээ байгуулж ажиллаагүй	1	4.9			1	4.9						
10	Байгаль хамгаалагч Л.Энхнаранд 1.5 сая төгрөгийн сургалтын дэмжлэгийг хувийн дансанд шилжүүлсэн	1	1.5			1	1.5						

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

11	Тайлант онд соёлын төвийн 2025 оны ажлын тайлангийн урлагийн тоглолтын зардалд 14.7 сая төгрөгийг Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс зарцуулсан	1	14.7			1	14.7						
12	ЗДТГ-ын даргад 2024 онд сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон, 2025 онд дахин 3.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон	1	3.0			1	3.0						
Дүн		12	707.6			10	471.1	2	236.5				